

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2017 оны 01 дүгээр сарын 05

Оросын холбооны улсын Буриад улсын нийслэл Улаан-Үүд хотын дунд мэргэжлийн боловсролын улсын байгууллага М.Н. Ербановын нэрэмжит Буриадын хөдөө аж ахуйн коллежийн захирал Э.М.Галсандоржиев, Монгол улсын Төв аймгийн Эрдэнэ суман дахь "Эрдэнэ" МСҮТ-ийн захирал Д.Байгалмаа нар дараах гэрээнд гарын үсэг зурахаар охиролцсон болно.

1. Гэрээний зүйл

1.1. Тус гэрээ нь мэргэжлийн боловсролын тогтолцоонд Инженер, сурган хүмүүжүүлэгч ажилтуудыг туршлага солилцуулах ба судалгаа хийх зорилго бүхий байна.

1.2. Талууд боловсролын үйл ажиллагааны дараах чиглэлүүдийн хүрээнд түншлэлийн болон бие даасан ажил хэргийг явуулахдаа ижил тэгш зарчим дээр үндэслэн харилцан ашигтай хамтран ажиллана.


- Ерөнхий болон тусгай курсуудын сургалтын хөтөлбөр арга зүйг боловсруулах,
- Арга зүйн гарын авлага солилцох
- Суралцагсадыг мэргэжлийн салбарт бэлтгэх, үйлдвэрлэл сургалтын мастер, арга зүйч, менежер болон багш нарын мэргэжил дээшлүүлэх ба мэргэжлийн түвшинг ахиулах талаар мэдээлэл солилцох
- Танилцах аялал, аялал жуулчлалын маршрут хамтарсан үйлдвэрлэлийн дадлага болон цаг үеийн хөдөлмөрийн ажил, суралцагсадын амралтыг зохион байгуулах.
- Шинжлэх ухаан-практикийн бага хурал болон семинар, мэргэжлийн хичээлийн олимпиад, урлагийн наадам, спорт, байгаль хамгаалах, орон нутаг судлах үйл ажиллагаа зохион байгуулах.

2. Талуудын эрх үүрэг

2.1 Талууд дараах үүргийг хүлээнэ

- Гэрээнд заагдсан зүйлстэй холбоотой бүх чиглэлээр мэдээллийг цаг тухайд нь /лавтай/ танилцуулах
- Сургалт үйлдвэрлэлийн түвшинд зохиогдох хамтын үйл ажиллагааг явуулах, зохион байгуулахад зайлшгүй хамтран ажиллах
- Мэргэжлийн ур чадварын уралдаан, семинари шинжлэх ухааны практикийн бага хурал, үзэсгэлэн, үзэсгэлэн худалдаа гэх мэт үйл ажиллагаанд оролцох төлөөлөгчдийг харилцан илгээх
- Санхүүгийн болон бусад материаллаг хангамжийг гэрээнд тусгагдсан тусгай гэрээ хэлэлцээрийн дагуу хамтын төсөв хөтөлбөрт оруулах

КОПИЯ ВЕРНА
ГБПОУ «БУРЯТСКИЙ АГРАРНЫЙ
КОЛЛЕДЖ ИМ. М.Н. ЕРБАНОВА»

Дондокова О.Р. 

-Хөдөлмөрийн аюулгүй байдал гал түймрийн аюулгүй байдал байгаль хамгаалах аюулгүй байдал , хувийн эрүүл ахуй урьсан талын олон улсын визний хугацаанд амьдрах норм зэргийн техникийн дүрэм журмыг баримтлах , өөрийн төлөөлөгчдөд тээврийн болон томилолтын зардлыг олгох

-Хамтын үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн зохион байгуулсан үйл ажиллагааг шударгаар удирдан зохион явуулах

-Хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх бэхжүүлэхийг эрмэлзэх

3. Талуудын хүлээх хариуцлага

3,1 Талууд нь бүх хариуцлагыг санал нэгтэйгээр үүссэн үндэслэлээс шалтгаалахгүйгээр хүлээнэ.

3,2 Хариуцлага хүлээгээгүй тохиолдолд эсвэл гэрээнд тусгагдсан гүйцэтгэх ёстой шаардлаганд хамаарахгүй дохиолдолд буруутай тал нь нөгөө талд учруулсан хохирлыг барагдуулна.

3,3. Талууд нь хэрвээ давшгүй хүчин зүйлээс үүссэн зүйл гарвал 3,2-т заасан хариуцлагаас чөлөөлөгдөж болно. Өөрөөр хэлбэл онцгой нөхцөл байдал болон тухайн нөхцөлийг биелүүлэх боломжгүй тохиолдолд

4. Маргааныг шийдвэрлэх

4,1 . Гэрээнд заасан нөхцөл байдлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор үүсч болох бүх маргаан ба зөрөлдөөнийг талуудын хэлэлцээрээр шийдвэрлэж болно.

4,2 . Хэлэлцээрийн замаар маргаан зөрөлдөөнийг тогтоох тохиолдолд ОХУ-ын Буриад улс болон Монгол улсын хууль тогтоох байгууллагын шийдвэрийн дагуу шийдвэрлэнэ.

5. Хүчинтэй хугацаа

5,1 . Энэхүү гэрээ нь хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 10 жилийн хугацаанд хүчин төгөлдөр болно.

5,2 . 10 жилийн хугацаа дуусмагц хэрвээ талуудын аль нэг нь бичгээр дахин гэрээг сунгахгүй талаар шийдвэрээ мэдэгдээгүй тохиолдолд автоматаар сунгагдана.

5,3 . Цаашид хамтран ажиллах боломжгүй эсвэл оновчгүй байдал үүссэн , сонирхогч тал сөрөг үр дүн гарахаас сэргийлэх байдал бий болгосон тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулах буюу хугацаанаас нь өмнө цуцалж болно.

6. Гэрээг цуцлах ба нөхцлийг өөрчлөх

ЗОНИЯ ВЕРНА
ГБПОУ «БУРЯТСКИЙ АГРАРНЫЙ
КОЛЛЕДЖ ИМ. М.Н. ЕРБАНОВА»

Дондокова О.Р.

6,1 . Гэрээний бүх нэмэлт өөрчлөлтийг хэрвээ бичгийн хэлбэрээр оруулсан буюу талуудын тусгай итгэмжлэгдсэн төлөөлөгчид гарын үсгээ зурсан бол хүчин төгөлдөр болно.

6,2. Гэрээ нь талуудын аль нэгнийх нь санаачлагаар хугацаанаас нь өмнө цуцалж болно . Энэ тохиолдолд санаачлагч тал нь нөгөө талд гэрээг цуцлах талаараа сараас багагүй хугацааны дотор мэдэгдэх ёстой.

7. Сүүлийн нөхцөл

Гэрээ нь 2 хувь хийгдэнэ. Талуудын аль аль тал нь ижил хуулийн этгээдтэй байна. Хувь бүрийн эх нь орос хэл дээр байна.

Улаан-Үүд хотын дунд мэргэжлийн

боловсролын улсын байгууллага
М.Н.Ербановын нэрэмжит Буриадын
хөдөө аж ахуйн коллеж

Захирал

Э.М.Галсандоржиев

Төв аймгийн Эрдэнэ суман дахь



Үйлдвэрлэлийн

Захирал

Д.Байгалмаа

КОПИЯ ВЕРНА
ГБНОУ «Бурятский аграрный
колледж им. М.Н. Ербанова»

Дондокова О.Р.